



МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ
СҮЛЖЭЭ ХХК

2025

ҮЙЛ АЖИЛАГААНЫ
ТАЙЛАН

НЭГ. КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАНИЛЦУУЛГА


1.1 БАЙГУУЛЛАГЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК нь өөрийн эзэмшлийн харилцаа холбооны дэд бүтцэд суурилсан сүлжээний үйлчилгээг 21 аймаг, 301 сум, суурин газрыг хамарсан нийт 20,110 км урт шилэн кабелийн сүлжээ, Улаанбаатар хот болон хөдөө орон нутагт байрлах 14,415 холбооны худаг, 1,055,151 метр урттай сувагчлал, 463 суурин газарт байрлах техникийн зориулалттай барилга байгууламж, 399 холбооны цамхгийг Монгол Улсын үндсэн сүлжээ болох уг дэд бүтцээрээ өөрийн чиг үүргийн дагуу мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудад ижил тэгш нөхцөлөөр, ил тод, үл ялгаварлах нөхцөлөөр үйлчилгээгээ хүргэж байна.

Тус компани нь үндсэн болон гэрээт нийт 1268 инженер, техникийн ажилтантайгаар улс, хот хооронд болон орон нутгийн дамжуулах байгууламжийг хамарсан мэдээлэл, холбооны үндсэн сүлжээний байнгын тасралтгүй, найдвартай ажиллагааг хангаж, мэргэшсэн үйл ажиллагаа явуулж Мэдээлэл, харилцаа холбооны салбарын хөгжилд хувь нэмрээ оруулан, төрийн болон хувийн хэвшлийн нийт 308 байгууллагатай хамтран ажиллаж, дэд бүтцийн үр ашиг, хамтын ажиллагааны хүрээг өргөжүүлж байна.


Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн харилцаа холбооны үндсэн сүлжээний дэд бүтэц, мэргэжлийн баг хамт олон нь тус компанийн зах зээлд эзлэх байр суурийг бэхжүүлж, орон даяар мэдээлэл, холбооны чанартай үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, шинэ технологийн дэвшлийг нэвтрүүлэх, найдвартай ажиллагааг хангахад нэн чухал үүргийг гүйцэтгэж байна.

Зураг 1. Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн үндсэн сүлжээ




ХОЁР. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Зураг 2. Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн бүтээгдэхүүн үйлчилгээ




Нэг. Сувгийн үйлчилгээ

Тоон суваг түрээслүүлэх үйлчилгээг төрийн болон бизнесийн 19 байгууллагатай 24 гэрээний хүрээнд 378 суурин газарт (аймаг, сум, баг, боомт) 126,151 Мбит/сек урсгал борлуулан үйлчилгээ үзүүлж байна.



Хоёр. Интернетийн бөөний үйлчилгээ



Интернетийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл бүхий-6 компанитай гэрээ байгуулж, 5,500 Мбит/сек интернэт урсгал борлуулан ажиллаж байна. Тус компани ОХУ-ын Мегафон, Транстелеком, БНХАУ-ын Чайна Телеком, Чайна Юником компаниудтай хамтран Ази-Европийг холбосон улс хоорондын 6х100Гбит/сек транзит урсгал дамжуулж байна.

Гурав. Шөрмөс түрээслүүлэх үйлчилгээ


Хотын доторх шөрмөс түрээслүүлэх үйлчилгээг 9 байгууллагатай гэрээ байгуулан 153.6 км шөрмөс түрээслүүлж байгаа бол Хот хооронд шөрмөс түрээслүүлэх үйлчилгээг 5 компанитай хамтран ажиллаж 8,415.7 км шөрмөс түрээслүүлэх үйлчилгээ үзүүлж байна.



Дөрөв. Тоног төхөөрөмжийн байр, цамхаг, оффисын байр талбай түрээсийн үйлчилгээ

Тоног төхөөрөмжийн байр, цамхаг түрээслүүлэх байр талбайн түрээсийн үйлчилгээний хүрээнд нийт 85 түрээслэгчтэй 304 байршилд түрээсийн гэрээгээр хамтран ажиллаж байна.

Улаанбаатар хот, 20 аймаг, 2 дүүрэг, 22 суманд нийт 12,669.98 мкв бүхий байр талбайг түрээслүүлж 212 гэрээ байгуулж, хамтран ажиллаж байна.




Тав. Худаг, сувагчлалын үйлчилгээ

Харилцаа холбооны сүлжээний хэвийн, найдвартай ажиллагааг хангах зорилгоор улс даяар 14,415 худаг, 1,055,151м сувагчлалын сүлжээ ашиглан үйл ажиллагаа явуулж байна.

УБ хотын хэмжээнд 7 станцын хүрээнд 9517 ш худаг, 668.2 км сувагчлал, аймаг орон нутагт 4,898ш худаг, 386.8 км сувагчлалын ашиглалт үйлчилгээг хариуцан ажиллаж байна.

Улаанбаатар хотын хэмжээнд нийт 124 түрээслэгчтэй давхардсан тоогоор 6,783 чиглэлд 6,536.4 км сувагчлал, 89,047 ш худаг, 5,146ш агаарын багана түрээслүүлэн гэрээгээр хамтран ажиллаж байна.




Зургаа. Техник менежмент

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК нь Монгол улсын хэмжээнд Улаанбаатар хот, 21 аймаг, 392 сум, суурин газрыг хамарсан мэргэшсэн хүний нөөцийн боломжид тулгуурлан харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгч байгууллагуудын 1,995 сайтад 54,369 удаагийн тогтмол үзлэг, шалгалт, 110 мянга орчим цагийн эрчим хүчний тасалдлын үед нөөц тэжээлийн үүсгүүр ажиллуулж тасралтгүй ажиллагааг ханган ажиллалаа.

Мөн 516 сайтын дэд бүтэц, тоног төхөөрөмж, улс, хот хооронд болон аймаг, сум доторх 3,816 км шилэн кабелийн трасст иж бүрэн урьдчилан сэргийлэх үзлэг, үйлчилгээ хийж, алслагдсан багуудад байрлах сайтуудын сүлжээний найдвартай ажиллагааг хангах хүрээнд 2,437 удаагийн сүлжээний гэмтэл, саатлыг арилгах, сүлжээний өргөтгөл хийх, шинэ сайтын хайгуул, сүлжээний чанарыг шалгах, тоног төхөөрөмжийг зөөвөрлөн шилжүүлэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгээд байна.

Зураг 3. Операторуудын сайтын тоо



Уг үйлчилгээний хүрээнд 2025 онд Мобиком Корпораци ХХК, Юнител ХХК, Скайтел ХХК, Жимобайл ХХК -тай 1,995 сайтыг хариуцан ажиллах “Ашиглалт үйлчилгээний гэрээ”, давхардсан тоогоор 1,500 орчим сайтад эрчим хүч, нөөц тэжээлээр хангах гэрээ, мөн Боловсролын мэдээллийн төвийн орон нутгийн 490 сургуулийг хамарсан боловсролын сүлжээ, Нийслэлийн мэдээлэл технологийн газар, Улаанбаатар хотын замын хөдөлгөөний удирдлагын төв, Исатком ХХК, Төрийн банкны сүлжээний захиалгат ажил гүйцэтгэх гэрээг тус тус байгуулан ажиллаж байна.

2026 оны төлөвлөгөөний хувьд дөрвөн оператор компаниудтайгаа харилцан тохиролцсоны үр дүнд орон нутгийн сүлжээний техникийн үзлэг, үйлчилгээний ажил гүйцэтгэх гэрээний сайт хариуцах хөлс, үзлэг үйлчилгээний ажлын хөлс, томилолтоор ажиллах инженер техникийн ажилтнуудын хөлс зэрэг дээр 10-25 хувийн өсөлт авч ажиллаж байна.

Долоо. Мэдээллийн аюулгүй байдлын аудитын үйлчилгээ

“Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын жагсаалт”-д багтсан 216 байгууллагад мэдээллийн аюулгүй байдлын аудит болон кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээний үйлчилгээний талаар хамтран ажиллах санал болон хэрэгжүүлэх боломжит үйлчилгээний багцыг боловсруулан хүргүүлж, хамтран ажиллаж байна.

Уг үйлчилгээг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас 2024 онд олгосон зөвшөөрлийн дагуу хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд одоогийн байдлаар Дарханы дулааны сүлжээ ТӨХХК, Сэтгэцийн эрүүл мэндийн төв, Мобиком Корпорац ХХК, Моби Финанс ББСБ зэрэг байгууллагад Мэдээллийн аюулгүй байдлын аудит болон кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг холбогдох хууль, журмын дагуу гүйцэтгээд байна.

Үндэсний Итгэмжлэлийн Төвөөс “Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо ISO/IEC 27001:2022” стандартын баталгаажуулалтын эрх авахтай холбоотой бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

ГУРАВ. ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ДОТООДЫН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД



Мэдээлэл холбооны сүлжээ компани нь 2025 онд Нийслэлийн засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн А/749 тоот захирамжийн дагуу Баянзүрх дүүргийн 26-р хороонд зохион байгуулагдах “Цөлжилттэй тэмцэх тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагуудын 17 дугаар бага хурал”-ын түр байгууламжийг холбоожуулах Багц-5 Гадна холбооны дэд бүтцийн ажил мөн Нийслэлийн засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн А/139 тоот захирамж тушаалын дагуу Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газрын санхүүжилтээр хэрэгжүүлэх “Улаанбаатар хотын нийтийн төв номын сан”-ийн өргөтгөлийн барилгын ажлыг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангаж барилга барих газрын доорх Мэдээлэл холбооны 168 метр хоолой бүхий 2352 метр 19 ширхэг шилэн болон физик кабелийг нүүлгэн шилжүүлэх, мөн гадна холбооны 4м урт (2+0) сувагчлал хийх ажлуудыг хийж гүйцэтгээд байна.

Нэг. COP17 дугаар бага хурлын түр байгууламжыг холбоожуулах дэд бүтцийн ажил:

Төслийн нэр:

Баязүрх дүүргийн 26-р хороонд зохион байгуулагдах “Цөлжилттэй тэмцэх тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын 17 дугаар бага хурал”-ын түр байгууламжийг холбоожуулах Багц-5 Гадна холбооны дэд бүтцийн ажил

Захиалагч байгууллага:

Нийслэлийн засаг даргын тамгын газар

Зураг 5. Гадна холбооны ажлын зураг



Мэдээлэл холбооны сүлжээ компани нь Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай байгуулсан гэрээний хүрээнд дээрх ажлуудыг Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын захиалагчийн хяналт дор төлөвлөсөн хугацаанд чанарын шаардлага, техникийн стандартын дагуу бүрэн гүйцэтгэж, холбогдох журмын дагуу улсын комисс ажиллуулан хүлээлгэн өгч ажиллаа.

Хоёр. “Улаанбаатар хотын нийтийн төв номын сан”-ийн өргөтгөлийн барилгын ажил:

Төслийн нэр: “Улаанбаатар хотын нийтийн төв номын сан”-ийн өргөтгөлийн барилгын ажлыг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангаж барилга барих газрын доорх болон гадна холбооны ажил

Хийгдэх ажил:	Мэдээлэл холбооны 168 метр хоолой бүхий 2,352 метр 19 ширхэг шилэн болон физик кабелийг нүүлгэн шилжүүлэх ажил	Гадна холбооны 4м урт (2+0) сувагчлал хийх ажил
---------------	--	---

Захиалагч байгууллага:	Нийслэлийн соёл урлагийн газар	Нийслэлийн засаг даргын тамгын газар
------------------------	--------------------------------	--------------------------------------

Гүйцэтгэгч байгууллага:	Мэдээлэл холбооны сүлжээ ХХК
-------------------------	------------------------------

Ажил эхэлсэн огноо:	2025 оны 03 дугаар сарын 18-ны өдөр	2025 оны 10 дугаар сарын 20-ны өдөр
---------------------	-------------------------------------	-------------------------------------

Ажил дууссан огноо:	2025 оны 05 дугаар сарын 15-ны өдөр	2026 оны 04 дүгээр сарын 01-ны өдөр
---------------------	-------------------------------------	-------------------------------------

Ажил гүйцэтгэсэн байршил:	Сүхбаатар дүүргийн 2 дугаар хороо, 5 дугаар хороолол-2 бүсчлэл Сөүл гудамж	Сүхбаатар дүүрэг 2 дугаар хороо, Нацагдоржын нэрэмжит Улаанбаатар хотын нийтийн төв номын сангийн барилга өргөтгөл
---------------------------	--	--

Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон Нийслэлийн соёл урлагын газаруудтай байгуулсан гэрээний хүрээнд дээрх ажлуудыг төлөвлөсөн хугацаанд чанарын шаардлага, техникийн стандартын дагуу бүрэн гүйцэтгэж, холбогдох журмын дагуу улсын комисс ажиллуулан хүлээлгэн өгч ажиллаа. Нийслэлийн засаг даргын тамгын газартай байгуулсан гэрээнд захиалагчийн хяналтыг Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар хэрэгжүүлж ажиллалаа.


Гурав. Нийтийн эзэмшлийн явган зам, талбайн тохижилтын ажил:

Нийслэлийн Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн А/1204 тоот захирамжийн дагуу Нийтийн эзэмшлийн явган зам, талбайн тохижилтын ажлыг нийслэлийн хэмжээнд 8 чиглэлд хийж гүйцэтгэж байна.

Энхтайвны өргөн чөлөө, Чингисийн өргөн чөлөө, Бага тойруу болон Их тойруу чиглэлд хийгдэж буй өргөтгөл, шинэчлэлийн ажлын үр дүнд нийт 22,832 метр сувагчлал, 106 худаг шинээр суурилуулж, 436 худгийн түвшинг шинэчлэн тохируулах ажлууд хийгдэж байна.

Төслийн нэр:	Нийтийн эзэмшлийн явган зам, талбайн тохижилтын ажил
Захиалагч байгууллага:	Нийслэлийн засаг даргын тамгын газар
Гүйцэтгэгч байгууллага:	Мэдээлэл холбооны сүлжээ ХХК
Ажил эхэлсэн огноо:	2025 оны 06 дугаар сарын 30-ны өдөр
Ажил дуусах огноо:	2026 оны 12 дугаар сарын 05-ны өдөр
Ажил гүйцэтгэсэн байршил:	<ul style="list-style-type: none"> ❖ Яармагийн уулзвараас АПУ ХХК-ийн хойд зам хүртэл ❖ Офицеруудын ордоны авто замын уулзвараас Зүүн 4 замын авто замын уулзвар хүртэл ❖ Саппорогийн авто замын уулзвараас 25 дугаар эмийн сангийн уулзвар ❖ Геологийн төв лабораториос Саппорогийн уулзвар хүртэл ❖ 19 автобусны буудлаас Саппоро хүртэл /замын хойд талаар/ ❖ Барилыг хөгжлийн төвөөс Зүүн 4 замын уулзвар хүртэл, ❖ Цэцэг төвөөс Багшийн дээдийн уулзвар хүртэл авто /замын урд талаар/, ❖ ХУД 120 мянгатаас Тэмээтэй хөшөө хүртэл


Зураг 6. Нийтийн явган зам, талбайн тохижилтын ажлын зураг




Зураг 7. Энхтайваны өргөн чөлөө /Геологийн төв лаборатороос Офицеруудын ордон хүртэл/



Зураг 8. Яармагийн гүүрний уулзвараас АГУ ХХК-ийн хойд зам хүртэл, Төв шуудангийн уулзвар хүртэл




Зураг 9. Бага тойруугийн гудамж



Зураг 10. Их тойруугийн гудамж



Зураг 11. Хан-Уул дүүрэг 120 мянгатаас Тэмээтэй хөшөө хүртэл



Хүснэгт 2. Нийтийн эзэмшлийн явган зам, талбайн тохижилтын ажлын гүйцэтгэл

Д/д	Ажил гүйцэтгэж буй чиглэл	Гүйцэтгэл
1	Яармагийн уулзвараас АПУ ХХК-ийн хойд зам хүртэл	78,4%
2	Геологийн төв лабораториос Саппорогийн уулзвар хүртэл /Авто замын урд тал/	100%
3	Геологийн төв лабораториос Саппорогийн уулзвар хүртэл /Авто замын хойд тал/	18,6%
4	Саппорогийн авто замын уулзвараас 25-р эмийн сангийн уулзвар /Авто замын хойд тал/	49,8%
5	120 мянгатын Тэмээтэй хөшөөнөөс Эрэл компанийн уулзвар хүртэл	25%
6	Зүүн 4 замаас офицеруудын ордоны тойрог хүртэл /Авто замын хойд болон урд тал/	100%
7	Цэцэг төвөөс багшийн дээдийн уулзвар хүртэл /Авто замын урд тал/	80%
8	Барилгын хөгжлийн төвөөс зүүн дөрвөн замын уулзвар хүртэл /Авто замын урд тал/	24%

Нийтийн эзэмшлийн явган зам, талбайн тохижилтын ажлыг нийт 8 чиглэлээр хэрэгжүүлж байгаа бөгөөд үүнээс 2025 онд 2 чиглэлийн ажил 100 хувийн гүйцэтгэлтэйгээр бүрэн дууссан. Харин үлдсэн чиглэлүүдийн ажлыг 2026 оны ажлын төлөвлөгөөнд тусган шат дараатайгаар үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

ДӨРӨВ. ТЕХНИК ТЕХНОЛОГИ, СҮЛЖЭЭНИЙ БАГТААМЖ, БЭЛЭН БАЙДЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

Тайлант хугацаанд үндсэн сүлжээний бэлэн байдлын үзүүлэлт (KPI) 99.98%, өгөгдлийн сүлжээний бэлэн байдлын үзүүлэлт (KPI) 99.99%, Улс хоорондын сүлжээний бэлэн байдлын үзүүлэлт (KPI) 100%, Кабель шугам (KPI) 99.77% гарч нийт сүлжээний бэлэн байдлын үзүүлэлтийг хангаж ажилласан байна. Компанийн “Гэмтэл саатлын нөхцөл байдлын үед ажиллах журам”-д заасны дагуу сүлжээний чанарын бэлэн байдлын түвшинг дараах байдлаар тогтоосон.

Компанийн хэмжээний дэд бүтэц, дамжуулах байгууламж, өгөгдлийн сүлжээ, худаг сувагчлалын байгууламж, кабель шугамын байгууламжийн үйл ажиллагааг хэвийн найдвартай явуулахад технологи болон чанарын удирдлагаар хангаж, сүлжээний бэлэн байдлын үзүүлэлт KPI үнэлгээг тооцон гаргаж ажиллалаа.


Тайлант хугацаанд “Гэмтэл саатлын нөхцөл байдлын үед ажиллах журам”-д заасны дагуу нийт сүлжээний бэлэн байдлын үзүүлэлтийг хангаж ажилласан.

Хүснэгт 3. Сүлжээний чанарын бэлэн байдлын түвшин

Д/д	Төрөл	Хэмжих нэгж	Чанарын түвшин /KPI/	Гүйцэтгэл /KPI/
1	Үндсэн сүлжээний бэлэн байдал	%	≥99.95	99.98
2	Өгөгдлийн сүлжээний бэлэн байдал	%	≥99.95	99.99
3	Улс хоорондын сүлжээний бэлэн байдал	%	≥99.98	100.00
4	Кабель шугамын бэлэн байдал	%	>98.5	99.77

Сүлжээний чанарын бэлэн байдлын түвшинг өмнөх онтой харьцуулахад (KPI) 0,06%-иар сайжирсан үзүүлэлттэй байна.

Зураг 12. Сүлжээний бэлэн байдлын түвшин



Үндсэн сүлжээ: 2025 онд нийт 93 удаагийн гэмтэл гарч 598.63 цаг үргэлжлэн 98,487 Мбит/с урсгал саатсан. KPI гүйцэтгэл 99.98% байна.

Хүснэгт 4. Үндсэн сүлжээнд гарсан гэмтлүүд

Төрөл	Удаа	Үргэлжилсэн хугацаа /цаг/	Саатсан урсгал /Мбит/сек/
Зай тэжээл	3	7.78	336
Тоног төхөөрөмж	6	14.21	6.591
Шилэн кабель	84	576.64	91.560
Нийт дүн	93	598.63	98,487



2025 оны зай тэжээлийн гэмтэл 3 удаа, тоног төхөөрөмжийн гэмтэл 6 удаа /свитчийн ажиллагаа, 10G карт доголдох зэрэг гэмтлүүд/, шилэн кабелийн гэмтэл 84 удаа /дийлэнх нь 5,7,8 дугаар саруудад байгаль цаг уурын нөлөөллөөс шилэн кабель тасарсан / байна. Зай тэжээлийн гэмтэл 50%, шилэн кабелийн гэмтлийг 16,49% тус тус буурсан үзүүлэлттэй байна.


Өгөгдлийн сүлжээ: 2025 онд нийт 64 удаагийн гэмтэл гарч 254.95 цаг үргэлжлэн 83,232 Мбит/с урсгал саатсан. KPI гүйцэтгэл 99.98% байна.

Хүснэгт 5. 2025 онд Өгөгдлийн сүлжээнд гарсан гэмтлүүд

Д/д	Төрөл	Удаа	Гэмтэл үргэлжилсэн хугацаа /цаг/	Саатсан урсгал /Мбит/сек/
1	Тоног төхөөрөмж	27	76.22	41299
2	Программ хангамж	12	23.97	22198
3	Холбох хэрэгсэл	5	32.05	2804
4	Зай тэжээл	13	18.57	11367
5	Шилэн кабель	4	101.37	948
6	Хүний буруу	2	0.92	3401
7	Шалтгаан тодорхойгүй	1	1.85	1215
	Нийт дүн	64	254.95	83,232

Өмнөх онтой харьцуулахад өгөгдлийн сүлжээнд гарсан гэмтлийн удаа 16-аар буюу 33.33%-иар өссөн байгаа нь ихэвчлэн эрчим хүч тасалдлаас шалтгаасан байна.

Зураг 13. Өгөгдлийн сүлжээнд гарсан гэмтлийн харьцуулалт



Тайлант хугацаанд өгөгдлийн сүлжээний нийт гэмтлийн 42.18%-ийг тоног төхөөрөмжийн гэмтэл, 20.31% -ийг зай тэжээлийн гэмтэл, 18.75%-ийг свитчийн тохиргоо алдагдасны улмаас үүдэн гарсан гэмтлийг тус тус эзэлж байна. Иймээс 2026 онд одоо ашиглагдаж байгаа дата свичүүдийг ашиглалтаас гаргаж, PTN сүлжээг бүрэн ашиглалтад оруулах төлөвлөгөөтэй ажиллаж байна.


Улс хоорондын сүлжээ: 2025 онд гэмтэл сааталгүй хэвийн ажилласан.

Кабель шугамын байгууламж: 2025 онд Хотын сүлжээний газар болон аймгийн газруудад 27 удаагийн гадны нөлөөтэй гэмтэл гарч нийт 203 цаг үргэлжилсэн байна.

Хүснэгт 6. 2025 онд Кабель шугамын байгууламжид гарсан гэмтлүүд

Төрөл	Удаа	Гэмтэл үргэлжилсэн хугацаа /цаг/
Гол кабель	0	0
Салбар кабель	11	66
Худаг сувагчлал	15	129
Агаарын багана	1	8
Нийт дүн	27	203

Зураг 14. Худаг сувагчлалын кабель шугамын гэмтэл



Тайлбар: Кабель шугамын байгууламжинд 2025 оны 7, 8, 10 дугаар саруудад нийт гэмтлийн 17-22 хувь тус тус бүртгэгдсэн байна. Энэ нь ОСНААУГ-ууд дулааны улирал эхэлсэнтэй холбоотой барилга руу татагдсан дулааны шугамын өргөтгөл шинэчлэлтийн ажил хийх явцдаа физик кабель болон сувагчлал гэмтээж хохирол учруулж байна.

Дулааны улиралд автозам, зам гүүр болон бусад инженерийн байгууламжийн шугам сүлжээний өргөтгөл, засварын ажил нэмэгддэгтэй холбоотойгоор 4 дүгээр сараас 10 дугаар сарын хооронд шилэн кабелийн гэмтэл хамгийн их гардаг. Иймд дээрх ажлыг гүйцэтгэж буй аж ахуйн нэгж, байгууллага болон хувь хүмүүс манай компанийн хот хоорондын шилэн кабельтай огтлолцож буй байршлуудад техникийн нөхцөл заавал гаргуулж, ажил эхлүүлэх зөвшөөрөл авч, хяналтын дор гүйцэтгэдэг бол энэ төрлийн гэмтлийг бууруулах боломжтой.

Техник, технологийн чиглэлээр хийгдсэн ажлууд:

Компанийн 2025 оны хөрөнгө оруулалтад нийт 28 багц ажлаас 23 багц ажил буюу 83 хувь нь техник технологийн чиглэлээр тусгагдсан нь технологийн компанийн тогтвортой үйл ажиллагаагаа явуулахад ямар нэг эрсдэл учирахад боломжит гүйцэтгэлийг оруулсан болно.

Техник технологийн хүрээнд дараах ажлуудыг хийж эхлүүлээ:

- ❖ Аймаг орон нутгийн газруудын шилэн кабелийн трассын нэгдсэн зурагтай болох ажлыг эхлүүлсэн. Аймаг сумдын шилэн кабелийн чиглэлийн судалгааг нэг бүрчлэн гаргаж ажиллалаа.

- ❖ China Unicom Japan компанийн интернетийн шинэ гарцыг ашиглалтад оруулж, байгууллагын бүх интернэт урсгалыг China telecom Group-ээс China Unicom Japan рүү амжилттай шилжүүлэв.
- ❖ Сүлжээний үндсэн төхөөрөмжүүдийн (Juniper MX480, Cisco ASR9904) байрлал, урсгалыг оновчлон өөрчилж, BGP routing table багтаамжийг нэмэгдүүлэн үйлчилгээний тасалдалгүйгээр шинэчлэл хийж ажиллалаа.
- ❖ Юнител ХХК-ийн харилцан холболтыг 16×10Гбит/сек болгон өргөтгөж, Транстелеком–ЧайнаТелеком чиглэлд 100Гбит/сек урсгалын шинэ суваг байгуулсан.
- ❖ Гурван сумын нутаг дэвсгэрт байрлах шилэн кабелийн трасст үнэлгээ хийж, эрсдэл бүхий хэсгүүдийг тодорхойлсон. Улмаар нийт 10 км урттай шилэн кабелийг аюул багатай байршилд шилжүүлэн суурилуулж, стандартын дагуу хамгаалалтын арга хэмжээг авч хэрэгжүүллээ.
- ❖ HPE MSA2060 storage серверийг 80ТВ багтаамжтайгаар дахин тохируулж, компанийн 18 чухал серверийг төвлөрүүлэн байршууллаа.
- ❖ Инженер, техникийн ажилчдад шаардлагатай нийт 15 нэр төрлийн 252 ширхэг багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг нийлүүлэн олгож, ашиглалт, бүрэн бүтэн байдалд тогтмол хяналт тавин ажилласан.
- ❖ Дамжуулах сүлжээний тасралтгүй, найдвартай ажиллагаа болон эрсдэлийн бэлэн байдлыг нэмэгдүүлэх зорилгоор хөргөлтийн төхөөрөмж 21 ширхэг, шулуутгагч 1 ширхэг, батарейн иж бүрдэл 23 багц-ыг технологийн шаардлагын дагуу суурилуулж, хэвийн ажиллагаанд оруулсан.
- ❖ Дамжуулах сүлжээний тасралтгүй ажиллагааг хангах зорилгоор шилэн кабель 20,5 км, худаг сувагчлалын хэрэгсэл 452 ширхэг, компанийн халуун нөөц тушаалын дагуу шаардлагатай 15 нэр төрлийн 1,245 ширхэг дагалдах материалыг худалдан авч нөөц бүрдүүлсэн.


ТАВ. ТӨЛӨВЛӨСӨН БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ

5.1 УЛС БОЛОН ХОТ ХООРОНДЫН ДАМЖУУЛАХ СҮЛЖЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР:

Улс болон хот хоорондын дамжуулах сүлжээний тасралтгүй, найдвартай ажиллагаанд 24/7 цагийн хяналт тавьж, салбаруудын техникийн бэлэн байдлыг хангуулах, гэмтэл саатлын үеийн хяналтын хугацааг мөрдүүлэх, ашиглалтын үйл ажиллагааг технологийн шуурхай удирдлагаар ханган ажиллаж байна.

Компанийн ашиглаж буй аймаг хоорондын их багтаамжийн нягтруулгын системийг 2017-2018 онд 68 байрлалд шинэ төхөөрөмж, 78 байрлалд өргөтгөл хийж өнгөрсөн 7 жилийн хугацаанд орон нутгийн дамжуулах сүлжээний ачаалал 20 дахин өсөх ачааллыг бүрэн даах суурь дэд бүтцийг байгуулан тус компанийн “Монголын Хөгжлийн Сүлжээ – 2021” стратегийг хэрэгжүүлэхэд нэн чухал үүрэг гүйцэтгэсэн. Одоо сумдын түвшний “PTN” төхөөрөмжийг суурилуулж өргөтгөхөд сүлжээний удирдлагын системийг U31 хувилбараас “ZENIC ONE” систем болгон сайжруулах, 12 үйлчилгээний NE (Network Element) байршлыг FOADM(Fixed Optical Add/Drop Multiplexer) байгааг бүрэн ROADM(Reconfigurable Optical Add-Drop Multiplexer) болгон шинэчлэх, үйлчилгээний бүрэн байдлыг хангах зорилгоор OTU хамгаалалт (redundancy) бүхий схем нэвтрүүлж, одоогийн картны 2.5Гбит/сек болон 10Гбит/сек хурдны λ (lambda)-г 100Гбит/сек болгон өргөтгөх шаардлага үүсч байсан бөгөөд 2025 оны 5 сард ТУЗ -ийн хурлаар санхүүжилтийг батлуулж “Аймаг хоорондын их багтаамжийн нягтруулгын төхөөрөмжийг өргөтгөх МХС/20250302044” төслийг эхлүүлээд байна.


Зураг 14. ZXONE 9700 дамжуулах төхөөрөмж солих чиглэл




БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй “Харилцаа холбооны хүртээмж, чанар, хяналтыг сайжруулах” төслийн хүрээнд Улаанбаатар хот болон 20 аймгийн төв, PTN6700, 281 суманд PTN 6700 болон 6120 дамжуулах сүлжээний тоног төхөөрөмжүүд

суурилуулсан. Мөн сүлжээний тохиргооны ажил хийгдэж, хэрэглэгчийн трафик шинэ төхөөрөмж рүү шилжүүлэх ажлыг эхлүүлээд байгаа бөгөөд 2026 оны эхний хагас жилд дуусгах төлөвлөгөөтэй ажиллаж байна

Зураг 15. Хуучин ажиллаж байсан тоног төхөөрөмжийн насжилтыг графикаар үзүүлэв



Зураг 16. Шинээр суурилуулсан PTN сүлжээний топологи зураг



5.2 УЛААНБААТАР ХОТЫН СҮЛЖЭЭ АШИГЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

Улаанбаатар хотын хэмжээнд 7 станцын хүрээнд 9,517 ш худаг, 668.2 км сувагчлал, 3,992 ш агаарын багана, аймаг орон нутагт 4,898ш худаг, 386.8 км сувагчлал, кабель шугамын байгууламжийн техникийн бэлэн байдал, сүлжээний хэвийн ажиллагаа болон Нийслэлийн Мэдээлэл Шуурхай Төвийн дүүргүүдийн Цагдаа, Эмнэлэг, Онцгой Байдлын Газрууд, Гудамжны хяналтын камерууд, Яаралтай Тусламжийн Төвүүдийг холбосон агаар, сувагчлалаар явсан нийт 115.36 км шилэн кабель, Нийслэлийн Мэдээлэл Шуурхай Төвийн бүх дүүргийн Засаг Даргын Тамгын Газрын Даргын Газар, нийт Хороодуудыг холбосон 207.54 км шилэн кабель, Замын Хөдөлгөөний Удирдлагын Төвийн бүх дүүргийн авто замын

гэрлэн дохио болон 1-р эгнээний хяналтын камеруудыг холбосон 127.8 км шилэн кабель, Мэдээлэл Холбооны Сүлжээ ХХК-ийн дамжуулах сүлжээгээр дамжиж байгаа улс хоорондох банкны урсгал, ТҮЦ машин, Дата төв, Хилийн Цэргийн Ерөнхий Газар, Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газар, Боловсролын яамны сургуулиуд, Тагнуулын Ерөнхий Газрын шилэн кабель зэрэг төр, хувийн хэвшил, аж ахуйн нэгжүүдийн сүлжээний найдвартай ажиллагаа ашиглалт үйлчилгээг хариуцан ажилладаг.



Газрын хэмжээнд нийт 1,112 цэгийн гэмтэл гарч хяналтын хугацаанд засварласан.



Хуваарилах шүүгээ 139, агаарын багана 1,145; телефон коропка 403, кросын блок 954-д үзлэг үйлчилгээ хийсэн.



Хайгуул хүсэлт 1,519; боломжтой хэрэглэгч 1,169, шинээр тавигдсан хэрэглэгч 292, шилжүүлэх үйлчилгээ хийгдсэн хэрэглэгч 217, гэрээ сэргээсэн 67, хэрэглэгч сулласан 2,341, Гол кабелийн 52,304*2 хос, Салбар кабелийн 25,305*2 хосод төлөвлөгөөт тулгалт хийсэн.



Гол кабелийн төлөвлөгөөт хэмжилтээр гол кабель 40,330*2 хос, салбар кабель 23,090*2 хос, цаг үеийн шаардлагаар урьдчилан сэргийлэх ажлын өмнөх 320*2 хос, дараах 420*2 хос, шинэ хүлээн авалтын 152*2 хос, гадны нөлөөгөөр гол кабель 300*2 хос, салбар кабель 1130*2 хосод тус тус нийт 65,742*2 хосын хэмжилт хийсэн.



Нийт 1,056 чиглэлд 12,443 худагт эргэлт үзлэг хийсэн.



7 бетонон таг шинээр суурилуулсан, 13 бетонон таг шилжүүлж, 79 таг хүзүү шинээр суурилуулж, 14 дээвэр шинээр суурилуулсан, 2 худгийн дээвэр засварласан, 20 таг хүзүү өндөрлөсөн, 2 таг хүзүү шилжүүлж, 1 таг хүзүү шавсан, 9 худаг дарсан, 15 худаг олсон, 176 худгийн ус шавхаж, 238 худгийн хог цэвэрлэсэн.



Станц хоорондын болон ашиглалт үйлчилгээ хариуцаж байгаа газруудын шилэн кабелийн 37 гэмтэл засварласан.



Шилэн кабелийн гүйцэтгэл шалгах: 106 чиглэлд 1,945 худгийн шилэн кабелийн гүйцэтгэл шалгаж хүлээн авсан.



Шилэн кабелийн акт тусгалт: 1,325 чиглэлд 4,526 худагт шинээр кабель бүртгэж зурсан.



Шилэн кабелийн акт хүлээн авах: 129 чиглэлд 2,725 худгаар 8 агаарын баганатай 204,256 м сувагчлалтай акт хүлээн авч бүртгэсэн.



Шинэ хүлээн авалтын гүйцэтгэлийн зургийн хэмжилт: 97 чиглэлд 260 худаг 20598 м сувагчлал газар дээр явж хэмжилт хийж хүлээн авсан.



Шинэ хүлээн авалтын акт тусгалт: 375 чиглэлд 400*2 хосыг хүлээн авч хэрэгт тусгаж мэдээллийн санд бүртгэсэн.

5.3 ДОТООД ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР

Дотоод хяналт, шинжилгээний алба нь чиг үүргийн дагуу 2025 онд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”, компанийн Гүйцэтгэх захирлын 2020 оны А/37 дугаар тушаалаар баталсан “Дотоод хяналтыг зохион байгуулах журам”-ын хүрээнд компанийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлж ажиллалаа.

2025 онд Захиргаа, удирдлагын газрын Цахим үйл ажиллагааны хэлтэс, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хэлтэс, Дамжуулах сүлжээ ашиглалтын газар, Дархан-Уул, Сэлэнгэ, Дорноговь, Баян-Өлгий, Увс, Ховд, Дорнод, Сүхбаатар аймгийн газар зэрэг нийт 10 газар, хэлтсийн үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ үнэлгээ хийж гүйцэтгэлээ.

Хяналтаар 29 сумын салбар, 7 РРС, 7 нэгжид ажиллаж, технологийн ашиглалт үйлчилгээ, сүлжээний тоног төхөөрөмж, дэд бүтэцийн ашиглалт, ХАБЭА-н нөхцөл байдалтай танилцаж, заавар зөвлөмж өгч ажиллав.

Хүснэгт 6. Хяналт, шинжилгээ үнэлгээ хийсэн газруудыг доорх хүснэгтээр харуулав.

д/д	Аймаг, дүүргийн газар	Хяналтын баг ажилласан сум суурин газар
1	Сэлэнгэ аймгийн газар	Цагааннуур, Түшиг сумдын салбар
2	Дархан-уул аймгийн газар	Хонгор, Баруунхараа, Сүмбэр, Шарын гол сумдын салбар, 304-р РРС
3	Баян-Өлгий аймгийн газар	Ногоон нуур, Цагааннуур, Цэнгэл, Улаанхус сумдын салбар, 138-р РРС
4	Увс аймгийн газар	Зүүнхангай, Түргэн, Давст, Бөхмөрөн сумдын салбар,
5	Ховд аймгийн газар	Эрдэнэбүрэн, Буянт, Мянгад, Манхан сумдын салбар, 133-р РРС
6	Дорнод аймгийн газар	Сэргэлэн, Баяндун, Баян-Уул сумдын салбар, 215-р РРС
7	Сүхбаатар аймгийн газар	Сүхбаатар, Асгат, Дарьганга, Халзан, Мөнххаан сумдын салбар, 213-р РРС
8	Дорноговь аймгийн газар	Говьсүмбэр аймгийн салбар, Замын Үүд, Улаанбадрах сумдын салбар
9	Дамжуулах сүлжээ ашиглалтын газар	ДСАГ-ын төв байр, 3К РРС, 1К РРС
10	ЗУГ-ын ХАБЭА-н хэлтэс	Сансарын холбооны наран төв, УБХСАГ-ын КШ-63 тасаг, ААҮХ-ийн төв байрны харуул, жижүүрийн байр, сантехникийн тасаг, зурагтын эцэст байрлалттай компанийн авто граж
11	ЗУГ-ын Цахим үйл ажиллагааны хэлтэс	Орон нутгийн 21 аймгийн болон Багануур дүүргийн газрын ERP систем
	Нийт	29 сумын салбар, 7 РРС, 7 нэгж

Технологийн хяналтаар сүлжээний найдвартай тасралтгүй ажиллагаа, технологи, стандартуудын мөрдөлт, ХАБЭА-н болон галын аюулгүй байдлын хяналтыг гүйцэтгэж, холбогдох албан даалгаварыг хүргүүлж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж ажилласан. Гүйцэтгэлийн хяналтаар нийт 9 аймгийн газарт 11 газрын баримт бичиг, эрх баталгаажуулалтын зөрчлийг тогтоож, зөрчлийг арилгах үүрэг даалгавар өгч ажиллалаа.

2025 онд хийгдсэн хяналт, шинжилгээ үнэлгээгээр Сэлэнгэ аймгийн газар хангалттай сайн, Дархан-Уул, Баян-Өлгий, Увс, Ховд, Сүхбаатар аймгийн газрууд үйл ажиллагаа хэвийн, Дорнод, Дорноговь аймгийн газар ажил сайжруулах үнэлгээтэй дүгнэгдлээ.

5.4 ХӨГЖЛИЙН КАПИТАЛ-ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧИГЛЭЛЭЭР



- ❖ МУЗГ-ын тогтоолын хэрэгжилтийг хангаж, компанийн нийт 1345 орон тооноос Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 9/01 тоот тогтоолоор 78 орон тоогоор цөөлж, нийт 1268 орон тоотой үйл ажиллагаа явуулж байна.
- ❖ 2025 оны байдлаар Мэдээлэл холбооны сүлжээ ХХК нь Хөдөлмөрийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд заасны дагуу 50 хөгжлийн бэрхшээлтэй ажилтныг ажиллуулж байна.
- ❖ Жилийн эцсийн байдлаар 32 ажилтан хүүхэд асрах чөлөөтэй байна.
- ❖ Гүйцэтгэх захирлын 121ш А тушаал, 303ш Б тушаалыг хянаж боловсруулан батлуулж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллав.
- ❖ Компанийн хэмжээнд “Ахмадын сангийн үйл ажиллагааны журам”, “Хүүхэд хамгааллын бодлого”-ын төслийг боловсруулж, Гүйцэтгэх захирлын тушаалаар батлуулан, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.
- ❖ Компанийн эрх бүхий 42 албан тушаалтны ХАСУМ-ыг АТГ-т хянуулж, 105 албан тушаалтны ХАСХОМ-ыг хуулийн хугацаанд хүлээн авч, бүртгэсэн.
- ❖ Борлуулалт үйлчилгээ болон Түрээсийн гэрээтэй холбоотой бүх төрлийн 136 гэрээнд хуулийн нийцлийг хангаж ажиллаж байна.

Гүйцэтгэх захирлын баталсан тушаал, шийдвэр:

- ❖ 2025 оны 04 дүгээр сарын 01-ний №А/42 тоот тушаалаар нийт ажилтнуудын цалинг нэмэгдүүлж, ингэхдээ инженер техникийн ажилтнуудын цалинг 500,000 төгрөгөөр, дэмжин туслах нийтлэг мэргэжлийн ажилтнуудын цалинг 300,000 төгрөгөөр тус тус нэмэгдүүллээ.

- ❖ 2025 оны 10 дугаар сарын 23-ны №А/102 тоот тушаалаар компанийн "Цалингийн шатлалын журам"-ын дагуу Улаанбаатар хотоос 58, аймаг дүүргийн газруудаас 72, нийт 130 ажилтанд II-IV шатлалаар 130,000-1,380,0000 төгрөгийн хооронд шатлалын нэмэгдэл олгов. Энэхүү журам батлагдсанаас хойш буюу 2023-2025 онд нийт 497 ажилтан шатлалд хамрагдсан байна.

5.5 СУРГАЛТ, ХӨГЖЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

Сургалт хөгжлийн хэлтэс нь 2025 оны төлөвлөгөөний дагуу сургалтын төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэх, ажилтнуудын мэдлэг, мэргэжлийн ур чадварыг сайжруулах, ёс зүй хандлагыг дээшлүүлэх зорилгоор:

- ❖ Бүсчилсэн сургалт /Архив албан хэрэг хөтлөлт, Архивын өрөөний стандарт, Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт боловсруулах арга зүй, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй, ERP программ/
- ❖ Төлбөртэй сургалт /Кабельчны мэргэжил олгох сургалт/
- ❖ Өндөрт ажиллах аюулгүй ажиллагааны сургалт
- ❖ Камерын системийн анхан шатны сургалт

Нийт 6 төрлийн сургалтуудыг зохион байгуулж давхардсан тоогоор 2900 инженер техникийн ажилтнууд хамрагдсан байна.

2025 онд Сургалт, хөгжлийн хэлтэс нь үндсэн сургалтын эрхийн хүрээнд 4 удаагийн төлбөртэй сургалтыг зохион байгуулж 85 иргэнийг хамруулж, мэргэжил эзэмшүүлэн, чадамжийн гэрчилгээ олгов.

Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус дотоод сургалтуудыг хуваарийн дагуу зохион байгуулж, нийт 1600 ажилтныг хамруулав.

- ❖ CISCO /CCNA/ I, II шат сургалтад Дамжуулах сүлжээ ашиглалтын газрын 22 ажилтан суралцаж 70, 70 цагийн хичээлийг хөтөлбөрийн дагуу суралцаж сертификатыг гардуулав.
- ❖ CCNA-3: Enterprise Net working, Security and Automation багш бэлтгэх сургалтад 2 хүн суралцаж, багшлах эрхээ авсан.
- ❖ Архив, албан хэрэг хөтлөлтийн сургалт
- ❖ Эрүүл мэнд, харилцаа хандлага, хувь хүний хөгжлийн сургалт
- ❖ МҮХАҮТ-ийн Компанийн засаглалын гэрчилгээ олгох сургалт
- ❖ Монголын хүний нөөцийн институтын ХН-ийн менежментийн үндсэн сургалт
- ❖ "Huawei ISP Industry Update introduction" сэдвийн хүрээнд сургалт
- ❖ "Overall PTN Network and U31 Operations" сэдвийн хүрээнд сургалт

ISO 27001 сургалт: ISO27001:2022 Мэдээллийн аюулгүй байдал менежментийн тогтолцоо” Дотоод аудиторын сургалтад 3 хүн хамрагдаж, шалгалтаа амжилттай өгч сертификатаа авав.

Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сургалт:

- ❖ Ажил олгогч болон удирдлагуудын ХАБЭА сургалт

- ❖ Үйлдвэрлэлийн осол хурц хордлого судлан бүртгэх сургалт
- ❖ Галын аюулгүй байдлын сургалт
- ❖ AUTO CAD-ийн сургалт
- ❖ Гамшгаас хамгаалах сургалт
- ❖ Анхны тусламжийн сургалт

5.6 ЦАХИМ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

Компанийн дотоод үйл ажиллагаанд “Байгууллагын нөөцийн удирдлагын систем буюу ERP” системийг ашиглаж байгаа бөгөөд дэд системүүдийн хэвийн ажиллагааг хангах, архив, албан бичиг хэрэг, шуудангийн хөтлөлтийг цахим болон уламжлалт хэлбэрээр холбогдох хууль, тогтоомжийн дагуу хослуулан хөтлөх, хяналт тавих ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

- ❖ Баримт бичгийн удирдлагын системд өргөдөл гомдол ангилан бүртгэх боломжтой болгож ажиллаа.
- ❖ Helpdesk дамжуулан нийт 90 санал хүсэлт бүртгэгдсэнээс 96.67% буюу 87 санал хүсэлт шийдвэрлэв.
- ❖ Компанийн хэмжээнд аж ахуйн нэгж, байгууллагуудаас ирсэн бичгийн нийт тоо 2518 бүртгэгдсэнээс хариу шаардлагатай албан бичиг 100, үүнээс 81-ийг шийдвэрлэсэн байна. Мөн компаниас аж ахуйн нэгж, байгууллагуудад нийт 1390 албан бичиг илгээсэн байна.
- ❖ Гүйцэтгэх захирлын 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн А/73 дугаар тушаалаар “Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд дагаж мөрдөх журам”-ыг шинэчлэн боловсруулж батлуулан компанийн хэмжээнд ашиглаж байна.
- ❖ Гүйцэтгэх захирлын 2025 оны 11-р сарын 03-ны А/103 тоот тушаалаар компанийн “Архивын дүрэм”-ийг шинэчлэн боловсруулав.
- ❖ Гүйцэтгэх захирлын 2025 оны А/57, А/58 тоот тушаалаар компанийн тамга, тэмдэг түших ажилтан, хэвлэмэл хуудас хариуцсан ажилтнуудыг батлав.
- ❖ Гүйцэтгэх захирлын 2025 оны А/61 тоот тушаалаар БНШК-ийн дүрэм, комиссын гишүүдийг байгуулав.
- ❖ Гүйцэтгэх захирын 2025 оны А/96 тоот тушаалаар компанийн архивын улсын үзлэг зохион байгуулах комиссыг байгуулан Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт амжилттай шалгуулав.
- ❖ Гүйцэтгэх захирлын 2025 оны А/98 тоот тушаалаар компанийн архивын баримтад тооллого хийх комиссыг байгуулан ажиллаж, байнга хадгалагдах 920 хадгаламжийн нэгжийн 208,419 хуудас материал, 70 жил хадгалагдах 321 ш хадагламжийн нэгж, түр хадгалагдах 4,395 ширхэг хадгаламжийн нэгж, нийт цаасан суурьтай 5,636 хадгаламжийн нэгж байсныг тоолон, тооллогын комисс баталгаажуулав.
- ❖ ДХША, ТӨБЗГ, Төрийн аудитын байгууллага болон бусад хяналт, шалгалтын байгууллагуудад 2025 оны эхний 10 сарын ирсэн, явсан бичгийн хадгаламжийн

нэгжийг бэлтгэн, материалуудыг PDF хэлбэрээр жагсаалтын хамт илгээж, шалгуулсан бөгөөд Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгээр 87 хувийн үнэлгээ авсан байна.

- ❖ Компанийн “Мэдээллийн ил тод байдлын журам”-ыг хэрэгжүүлэх хүрээнд компанийн цахим хуудсанд 23 төрлийн төлөвлөгөө, тайлан мэдээллийг байршуулав.
- ❖ Ажлын байрны сул орон тооны 11 зар мэдээллийг байршуулж ажлын байрны зар мэдээлэл нь ил тод харагдахаар тохируулав.
- ❖ www.icn.mn цахим хуудсанд Мэдээллийн технологи, дотоод сүлжээний хэлтсийн инженертэй хамтран Удирдлагын баг болон Төлөөлөн удирдах зөвлөлийн цэсний байршлын тохируулга, мэдээлэл оруулах явцад гарч байсан source кодын алдааг засварлуулж, вебийн бааз өгөгдөлд шаардлагатай өөрчлөлт хийсэн. Мөн админ эрхээр текстийн өндөр, хэмжээ тохируулагдахгүй байсан асуудлыг шийдвэрлэж, техникийн нөхцөл болон албан бичгийн хүсэлт хүлээн авах үед илэрч байсан алдааг Интерактив компанитай хамтран сайжруулсан.
- ❖ ЦХИХХЯ-наас ирүүлсэн албан бичгийн дагуу Нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангах хуулийн хүрээнд www.shilen.gov.mn цахим хуудсанд 5 төрлийн 87 үзүүлэлт бүхий нээлттэй мэдээллийг улирал бүр байршуулж, үнэлгээ авсан бөгөөд 2025 оны байдлаар 100 хувийн үнэлгээтэй шалгагдсан.

5.7 ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР

Компанийн ажилтнуудын ажлын байрны аюулгүй байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүллээ.

- ❖ Компанийн Гамшгаас хамгаалах штабын гишүүд, үйлдвэрлэлийн ослын хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчлөл судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссийн бүрэлдэхүүнийг Гүйцэтгэх захирлын тушаалаар шинэчлэн батлуулсан.
- ❖ УБ хотын хэмжээнд шаардлагатай бүх төрлийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг тухай бүр өгч ажилласан бөгөөд урьдчилсан аюулгүй ажиллагааны зааварчилгааг 53, албан томилолтын үеийн зааварчилгааг 335 ажилтанд өгч, нийт 388 ажилтныг хамруулсан байна.
- ❖ Эрсдэл өндөртэй ажлын байранд ажилладаг ажилтнуудын судалгааг шинэчлэн, амь нас, эрүүл мэндийн даатгалд хамруулах ажилтнуудын судалгааг ТУТГ-т хүргүүлж, 21 инженер, техникийн ажилтныг нэмэлтээр даатгалд хамруулан, даатгалын гэрээнд тодотгол хийсэн. Нийт 175 инженер, техникийн ажилтанг даатгалд хамруулсан байна.
- ❖ ХАБЭА-н 2 болон 3 шатны үзлэгийн хүрээнд объектуудад тогтмол үзлэг шалгалт хийж гарсан зөрчлүүдийг тайлангаар танилцуулж хугацаатай үүрэг өгч ажилласан.
- ❖ “Гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохио дамжуулах журам”, “Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд зарлан мэдээллийн

- дохиогоор ажиллах нэгдсэн дадлага, сургуулийг компанийн хэмжээнд зохион байгуулж тайланг холбогдох дүүргийн онцгой байдлын хэлтэст хүргүүлж ажиллалаа.
- ❖ Дамжуулах сүлжээ ашиглалтын газрын харьяа радио релейн 1К, 103, 104, 303, 3К, 402, 403 болон Налайх салбарын галын дүгнэлтийг авч, РРС болон тоног төхөөрөмжийн өрөөнд автомат гал унтраах системийг суурилуулсан.
 - ❖ УБ хотын бүх объектод аваарын гэрэлтүүлэг, аюулгүй гарцын гэрэлтдэг тэмдэг, тэмдэглэгээ, автомат гал унтраах төхөөрөмжүүдийг байршуулж, компанийн төв байрны В1 давхраас 4 давхар хүртэлх галын гарцын схем зураглалыг хийж байршуулав.
 - ❖ Төв байранд галын автомат дохиолол суурилуулах ажлын зураг төсвийг Монкабель ХХК-аар хийлгүүлж бэлэн болгосон.
 - ❖ “Ажлын тусгай хувцас олгох журам”-ын дагуу 2025 онд захиалсан ажлын тусгай хувцас, гутлыг олгож, компанийн хэмжээнд ажлын багаж, хамгаалах хэрэгслийг захиалгын дагуу бүрэн хангаж олгосон.

ЗУНЫ АЖЛЫН ХУВЦАС	ӨВЛИЙН АЖЛЫН ХУВЦАС	ЗУНЫ АЖЛЫН ГУТАЛ	ӨВЛИЙН АЖЛЫН ГУТАЛ	АЖЛЫН ХАЛАД	АЖЛЫН ХАЛАД
372	384	371	384	36	133
	ӨНДӨРИЙН БҮС	ДӨРӨӨ	ГАГНУУРЫН БАГ	УСНЫ ГУТАЛ	
	13	25	14	75	

- ❖ Сувилахуй, эмнэлгийн тусгай мэргэжлийн тусламж, үйлчилгээний удирдлага, зохион байгуулалтын дүрэм, журмын дагуу эмнэлгийн тусламж, үйлчилгээний хэвийн ажиллагааг ханган ажилласан. Давхардсан тоогоор 429 ажилтанд артерийн даралт 656 удаа хэмжиж, албан томилолтоор явах ажилтнуудад анхан шатны үзлэг хийж, судас тариа 80, дусал тариа 690, булчин тариа 128 удаа хийсэн. Мөн толгой, хүзүүний бариа 171, бумба 172, УВЧ шарлага 298, искра шарлага 4, парафин лаа 82, шарх цэвэрлэж боолт 15 удаа хийж, анхан шатны эм, тариагаар 95 ажилтанд тусламж, үйлчилгээ үзүүлсэн байна.
- ❖ Байгууллагын нийт ажилчдыг эрүүл мэндийн хугацаат, урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах ажлын хүрээнд Healthroad ХХК-ын Клинико эмнэлэгтэй хамтран ажиллаж, нийт 306 ажилтанг үзлэг, оношилгоонд хамрууллаа.
- ❖ Жилийн давтан сургалтын хүрээнд “Анхны тусламж хэрхэн үзүүлэх вэ”, “Галын аюулаас урьдчилан сэргийлэх, гал гарсан үед ажиллах журам болон гамшиг, ослын үед хэрхэн ажиллах”, компанийн ХАБЭА-н дүрэм, галын аюулгүй байдлын сэдэвт болон бусад сургалтуудыг зохион байгуулж, ажилтан, ажиллагсдыг бүрэн хамруулж ажиллаа.

- ❖ ОБЕГ-ын Гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төвтэй хамтран зохион байгуулсан Гамшгийн үеийн дадлага сургуулилтад оролцсон.
- ❖ Мэдээлэл холбооны сүлжээ компанийн аймаг, дүүрэг, ашиглалтын газруудын дунд эрсдэлийг бууруулах, ажилтны амь нас, эрүүл мэндийг хамгаалах, үйлдвэрлэлийн ослыг тэглэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, шинэ санал, санаачилга гаргах, туршлага солилцох, улмаар тэдгээрийг үйл ажиллагаанд нэвтрүүлэх зорилгоор “ЭРСДЭЛГҮЙ, АЮУЛГҮЙ ОРЧИН” сэдэвт болзолт уралдааныг 2025 оны 04 дүгээр сарын 01-ээс 05 дугаар сарын 15-ны хооронд, нийт 45 хоногийн хугацаанд зохион байгуулж ажиллалаа.